

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2020.12.11.

Баруун-Урт хот.

Тус хэлтэс нь өөрийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлэх, Монгол Улсын Засгийн газар, аймгийн засаг даргын 2019 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, аймгийн Засаг даргаас Хууль зүй, дотоод хэргийн сайдтай байгуулсан гэрээний биелэлт, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргатай хэлтсийн даргын байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаанд хамаарах багц хуулиуд, холбогдох тогтоол шийдвэр, журмуудын хэрэгжилтийг хангахад гол анхаарлаа чиглүүлэн ажиллалаа.

Сүхбаатар аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс нь нийт 28 ажилтан албан хаагчидтайгаар бүртгэлийн үйлчилгээг аймгийн 62,9 мянган иргэнд хүргэж байна. Тус хэлтэс нь аймгийн Нутгийн удирдлагын ордны 1 давхарт байрлан нийт 5 өрөөг түрээсийн гэрээний дагуу ашиглаж үйл ажиллагаа явуулж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2019 оны А/909 дүгээр тушаалын хавсралтаар баталсан "Улсын бүртгэлийн байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээний аргачлал"-д тусгагдсан ажил, арга хэмжээг хэрэгжүүлж, гүйцэтгэлийг ханган 2020 онд зохион байгуулсан үйл ажиллагаагаа тайлагнаж байна. Үүнд:

1. Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө :

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газрын 37 дугаар тогтоолоор "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-ын дагуу төлөвлөгөөний төслийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан, арга хэмжээний шалгуур үзүүлэлт бүрийг тодорхой хугацаанд биелэгдэхээр төлөвлөн боловсруулж 2000 тэмдэгтэд багтаан товч тодорхой, бодитой, үг үсгийн алдааг хянан тогтоосон хугацаанд УБЕГ-т хүргүүлэн батлуулсан.

Хэлтсийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнөөс тасаг нэгжүүд, цаашлаад тасаг нэгжээс улсын бүртгэгч нартай төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэлтсийн даргатай байгуулж эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг УБЕГ хүргүүлсэн бөгөөд 86,3 хувьтай дүгнэгдсэн.

Хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Борхүү нь Аймгийн Засаг даргатай байгууллагын 2020 оны жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2020 оны 03 сарын 25-ны өдөр байгуулан аймгийн удирдлагуудад зохих мэдээ, мэдээллийг тухай бүр хүргэн хамтран ажиллаж байна.

2. Нэгжийн дотоод үйл ажиллагаа :

Аймгийн Засаг дарга Ж.Эрдэнэбаатар, Тамгын газрын дарга П.Мөнхжаргал, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга У.Болдхүү нар тус хэлтсийн албан хаагчидтай уулзалт зохион байгуулж, ажлын байрны нөхцөл байдалтай танилцсан. Тухайн үед алба хаагчдын ажиллах, ард иргэдэд үйлчилгээ үзүүлэх орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор засварын ажил хийх санал тавьсаны дагуу аймгийн удирдлагууд засвар хийх үүрэг,

чиглэл өгсөний дагуу мэргэжлийн байгууллагаар зураг, төсөв гаргуулан аймгийн Засаг даргын 2020 оны А/282 дугаар захирамжаар 8,011,500 төгрөгний дэмжлэг үзүүлсэн.


Үүнд 3 өрөөнд вакуум цонх, 1 өрөөнд хаалга, коридор бүхэлд нь паркетан шал хийлгэж, 6 өрөө коридорын хаана таазыг засварласан бөгөөд дээрх ажлуудыг хийхэд ажлын хөлс нь 2 сая төгрөг, үлдсэн нь засварын материалд зарцуулагдсан болно.

Ажлын байрны засварын ажил хийгдэж дууссан ба алба хаагчдын ажиллах, аж ахуйн нэгж, байгууллага, ард иргэдэд цэвэр, тав тухтай орчинд үйлчилгээ үзүүлэх нөхцөл боломж бүрдсэн.

Өмнө



Дараа



Шинэ төрлийн "COVID-19" халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Улсын Онцгой Комиссоос гаргасан уриалгыг дэмжиж Сүхбаатар аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн хамт олноос Аймгийн Онцгой Комисс-т 500,000 төгрөг хандивласан.



Улсын бүртгэлийн хэлтсээс нийт ажилтан албан хаагчиддаа дархлаа дэмжих бүтээгдэхүүн, маск, спирт, салимон, бээлий, нүүрний циллодон хаалт зэргийг тухай бүр өгч урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч байна.



Монгол улсын Авлигатай Тэмцэх газрын 2020 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 05/5036 тоот албан бичигт Архивын ерөнхий газар болон Үндэсний төв архивын дэргэдэх баримт бичиг нягтлан шалгах, арга зүйн комиссын хуралдаанаар албан тушаалтны цаасан хэлбэрээр гаргасан ХАСХОМ баталгааны маягтыг 70 жил, цахимаар гаргаж байгаа ХАСХОМ, баталгааны маягтыг бүртгэсэн бүртгэлийн дэвтрийг 70 жилээр тус тус хадгалж байгууллагын архивт шилжүүлж хадгалах чиглэлийн дагуу хэлтсийн төрийн захиргааны албан хаагчдын 2008-2019 онуудын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг, ХАСХОМ цахим хэлбэрээр мэдүүлсэн тухай баталгааны маягт, албан тушаалтнуудын хөрөнгө, орлогын мэдүүлгийн хураангуй бүртгэл, ХАСХОМ хүлээж авсан бүртгэлийн дэвтрийг он оноор нь жагсаалт үйлдэн албан хаагч бүрээр гарган дугаарлаж төрийн захиргааны нийт 22 албан хаагчдын 1507 хуудас материалыг байгууллагын архивт хүлээн авсан.

Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 3/3785 дугаар тоот чиглэлд дурьдагдсан хууль тогтоомж, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Төрийн захиргааны 22 албан хаагчдын 2019 оны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг цахим болон цаасан хэлбэрээр гаргуулан баталгааны маягтыг албажуулан авсан.


Тус хэлтсийн төрийн захиргааны 22, төрийн үйлчилгээний 4, гэрээт 2 албан хаагч, 2020 оны Монгол Улсын Их хурлын сонгуулийн 12 дугаар тойргийн хэсгийн хороодод ажиллах Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн 69 ажилтнаас төрийн болон албаны нууц задруулахгүй байх нууцын баталгааг гаргуулан авч хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаа.

Төрийн болон албаны нууцыг хадгалах, хамгаалах асуудлаар Сүхбаатар аймаг дахь Тагнуулын хэлтэстэй ажил хэргийн уулзалт зохион байгуулж тогтмол хамтран ажиллаж байна. Үүнд:

Монгол Улсын Их Хурлын болон аймаг, нийслэл сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн 2020 оны ээлжит сонгуулийн санал авах байранд ажиллах Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудын дунд зохион байгуулагдах ирц

бүртгэлийн программын дадлага ажлын сургалтыг тус тус зохион байгуулсан. Итгэмжлэгдсэн ажилтнуудын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг хангах зорилгоор холбогдох байгууллагын хамгаалалттай Улсын бүртгэлийн ерөнхий газраас татан авч сургалттай өдрүүдэд танхимыг хамгаалалтанд авч хамтран ажилласан бөгөөд сонгуулийн дараа Цагдаа, Тагнуулийн байгууллагын хамгаалалттай бүрэн бүтэн буцаан хүргэж өгсөн.

Төрийн болон албаны нууцын тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй “Тамга урлал” ХХК-д хүсэлт тавин 001-026 код бүхий 26 ширхэг суурьтай лацыг захиалан хэлтсийн нийт албан хаагчдад хүлээлгэн өгч өрөө тасалгаа болон тумбочик, сейфийг лацдан аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.



Жишээлбэл Сүхбаатар аймгийн Уулбаян сумын улсын бүртгэгч Б.Ишлхам нь төрийн болон албаны нууцын хадгалалт хамгаалалтын чиглэлээр сейфндээ лацны суурийг суурилуулан, нууц хамгаалах ажлыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Цайны завсарлага болон ажлын цаг тарах, ажлаас гарах тохиолдолд компьютер, тэмдэг, бүртгэлийн маягт, дэвтэр бусад тоног төхөөрөмжийг сейфндээ хийж, лацдан аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.



Аймгийн Гэр бүл, Хүүхэд залуучуудын хөгжлийн газраас “Эцэг эхийн зөвлөл байгуулж хамтран ажиллах зөвлөмж ирсний дагуу хэлтсийн даргын 2020 оны 01-р сарын 17- ны өдрийн Б/03 тоот тушаалаар байгууллагын эцэг эхийн зөвлөлийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан зөвлөлийн даргаар нягтлан бодогч С.Доржпагма, нарийн

бичгийн даргаар эд хөрөнгийн тасгийн улсын бүртгэгч Б.Одонзул, гишүүдэд Иргэний улсын бүртгэгч Э.Отгон, хуулийн этгээдийн улсын бүртгэгч Ц.Мөнхчимэг, жолооч, угтах үйлчилгээний ажилтан О.Алтангэрэл нар ажиллаж байна. Эцэг эхийн зөвлөл нь 2020 онд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төлөө хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хэлтсийн даргаар батлуулан төлөвлөгөөний дагуу биелэлтийг ханган ажиллаж байгаа болно.

Тус зөвлөлийн зорилго нь: Байгууллагын албан хаагчдын 57 хүүхдийн сурч боловсрох, гэр бүлийн тогтвортой байдлыг хангах, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх, хэлтсийн даргын Б/03 тоот тушаалын хэрэгжилтийг хангахад оршино. 2020 онд зөвлөлийн төлөвлөгөөний дагуу хийж хэрэгжүүлсэн ажлын нэг байгууллагын албан хаагчдын хүүхдийн судалгааг насны ангилалаар гаргаж хүүхдүүдийн хамгийн их тулгамдаж буй шүдний өвчлөлийг авч үзэн бүх хүүхдийн шүдийг АНЭ-ийн хүүхдийн шүдний эмч Энхнарантай зөвшилцөж 2020 оны 04-р сарын 28-аас 2020 оны 05-р сарын 06 ны өдрийг дуустал ажлын өдөр 1 цаг авч 2-18 насны нийт 23 хүүхдийн шүдний үзлэг, эмчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулан ажиллаа.



Аймгийн засаг даргын 2020 оны А/263 тоот захирамжаар “Хамгаалагдсан хүүхэд-Хариуцлагатай аав ээж аян”-ны хэрэгжилтийг ханган ажиллаж байна.


Энэ аяны хүрээнд ажилтан бүр “Covid-19”-тай холбогдуулан иргэний улсын бүртгэгч Э.Отгон албан хаагчдын гэрээр очин гараа тогтмол угаах, маскаа тогтмол зүүх, гэрийн орчны аюулгүй байдлын талаар заавар зөвлөгөөг өгсөн болно. Хэлтсийн дотоод ажлын зохион байгуулалтын үйл явцын хүрээнд албан хаагчдын ажлын цагын богиногосон хэлбэрт шилжин цар тахлын хүнд үед аав ээжүүд бага насны, хүүхдүүдээ хараа хяналтгүй орхих явдал багасаж байна.

Олон улсын “Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг угтсан хэлтсийн албан хаагчдын хүүхдүүдийн дунд 5-16 насны хүүхдүүдийн дунд “ТИК ТОК” ашиглан бичлэг хийх, 3-8 настай хүүхдүүдийн дунд “Уран уншлага уралдаан зохион байгуулагдаж нийт 15 албан хаагчийн 2-11 насны ангилалд 19 бүтээл ирж тэмцээн тус бүр дээр эхний 3 байрыг шалгаруулан уралдааныг нээлттэй зохион байгуулж амжилттай оролцсон хүүхдүүдийг урамшууллаа.



ОНОГОЛОН УУЛИЙН ЭРНИЙ ХАМГААЛАХ ӨДӨЙ ИТГЭГ ЭСЭН БҮРТГЭЛИЙН АЖИЛТНЫ ХУУЛИЙН ДЭГДЭЭЛЭЛЭН ҮР/ДААЖИЛТ

| № | Ажлынхэн | Хувиар | Төл | Төлөг | Төлөг | Төлөг | Төлөг |
|----|------------|-------------|-----|-------|-------|-------|-------|
| 1 | Б.Бор-Очи | Улаанбаатар | 100 | 7 | 10 | 0 | 0 |
| 2 | М.Мөнхсайр | Улаанбаатар | 100 | 12 | 0 | 13 | 0 |
| 3 | М.Мөнхсайр | Улаанбаатар | 100 | 12 | 0 | 13 | 0 |
| 4 | М.Мөнхсайр | Улаанбаатар | 100 | 12 | 0 | 13 | 0 |
| 5 | Б.Бор-Очи | Улаанбаатар | 100 | 7 | 10 | 0 | 0 |
| 6 | Б.Бор-Очи | Улаанбаатар | 100 | 7 | 10 | 0 | 0 |
| 7 | Б.Бор-Очи | Улаанбаатар | 100 | 7 | 10 | 0 | 0 |
| 8 | Б.Бор-Очи | Улаанбаатар | 100 | 7 | 10 | 0 | 0 |
| 9 | Б.Бор-Очи | Улаанбаатар | 100 | 7 | 10 | 0 | 0 |
| 10 | Б.Бор-Очи | Улаанбаатар | 100 | 7 | 10 | 0 | 0 |
| 11 | Б.Бор-Очи | Улаанбаатар | 100 | 7 | 10 | 0 | 0 |
| 12 | Б.Бор-Очи | Улаанбаатар | 100 | 7 | 10 | 0 | 0 |
| 13 | Б.Бор-Очи | Улаанбаатар | 100 | 7 | 10 | 0 | 0 |
| 14 | Б.Бор-Очи | Улаанбаатар | 100 | 7 | 10 | 0 | 0 |
| 15 | Б.Бор-Очи | Улаанбаатар | 100 | 7 | 10 | 0 | 0 |




Тус хэлтэс нь нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг хэвийн явуулж санхүүгийн тайлангуудыг хууль тогтоомжийн дагуу үнэн зөв гаргаж, 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн Үндэсний аудитын газрын дүгнэлтээр УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн шударга илэрхийлэгдэж “Итгэмжлэл” авсан.



Хэлтсийн даргын 2020.04.02-ны өдрийн Б/10 тоот тушаалаар жолооч О.Алтангэрэлийг жолооч, угтах үйлчилгээний ажилтнаар томилсон.

Угтах үйлчилгээний ажилтан нь иргэдэд бүртгэлийн үйлчилгээг ойртуулахад шаардлагатай мэдээ мэдээллийг хүргэх, чиглүүлэх, давхар албан хаагчдын цаг бүртгэлийг хянаж гадуур ажлын дэвтэр хөтлөх зэрэг ажлуудыг өдөр тутамдаа хийж гүйцэтгэж байна.



Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангах, ажилтан албан хаагчдын хувцаслалт, харагдах байдал, ажил хэрэгч байдлыг илтгэсэн жигд дүрэмт хувцастай болсон.



Хэлтсийн нийт албан хаагчдын хүсэлтээр Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журмын 7 дугаар зүйлийн 7.2, 7.4 дэх заалтуудыг үндэслэн 2020 оны 01 дүгээр сараас эхлэн ажлын цагт өөрчлөлт оруулан 08 цагт эхлэдэг байсан ажлын цагийн 08.30 минутанд эхлэж 17.30 минутанд дуусгаж, 12.30-13.30 минутын хооронд завсарлах зохицуулалтыг хийж өгсөн.

Албан хаагчдын үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх, гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг хянаж, холбогдох хууль тогтоомж, журам, албан тушаалын тодорхойлолтонд заасан ажил үүргийг баримтлан ажиллаж буй эсэхэд хяналт тавих, үнэлгээний дүнг нэгтгэн үр дүнг танилцуулах үүрэг бүхий “Байгууллагын үнэлгээний баг”-ийг 5 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллаж байна.

Хэлтсийн дарга өөрчлөгдсөнтэй холбогдуулан даргын зөвлөл, ёс зүйн хороог шинэчлэн байгуулсан.

Ажиллагсадын хөдөлмөрийг оновчтой зохион байгуулж, сахилга, хариуцлагыг өндөржүүлэх, албан хаагчдын ажиллах орчин нөхцлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах зорилгоор УБЕГ-ын хөдөлмөрийн дотоод журамтай уялдуулан байгууллагын дотоод журмыг батлан мөрдлөг болгон ажиллаж байна.

2020 оны 10 дугаар сарын 29-ны өдөр Сүхбаатар аймаг дахь Тагнуулын хэлтсээс байгууллагын болон албаны нууцын хадгалалт хамгаалалт баримт бичгийн бүрдэлд зөвлөн туслах чиглэлээр шалгалт хийсэн бөгөөд ямар нэгэн зөрчил илрээгүй болно.

Аймгийн Төрийн архивын тасаг нь тус хэлтсийн архивын баримтын хамгаалалт, хадгаламжийн сангийн нөхцөл байдал, хадгалалтын горимын үйл ажиллагаанд 2020 оны 10 дугаар сарын 13 -ны өдөр хяналт шалгалт хийсэн. Уг шалгалтын дүгнэлтэнд улсын бүртгэлийн хэлтсийн удирдлагын зүгээс байгууллагын хэвийн үйл ажиллагааг явуулах, иргэдэд түргэн шуурхай тохилог орчинд үйлчилгээ үзүүлэх зорилгоор аймгийн удирдлагуудад байрны нөхцөл байдлын танилуулан шинээр ашиглалтанд орох төр захиргааны 2-р байранд 290 мкв талбайтайбайрыг хүлээн авах гүйцэтгэгч компанитай зөвшилцөн иргэний бүртгэлийн болон эд хөрөнгө, хуулийн этгээдийн хадгалагдаж буй архивын өрөөг зориулалтын дагуу тохижуулах талаар харилцан тохиролцсон одоо явуулж буй архивын өрөө тасалгаа нь хэвийн үйл ажиллагаа явуулах боломжгүй байна

гэсэн дүгнэлтийг аймгийн архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагч М.Төрбаяр 2020.10.16-ны өдрийг 01 тоот дүгнэлт гарган Архивын ерөнхий газарт хүргүүлсэн.

Улсын бүртгэлтийн байгууллага үүсч хөгжсөний түүх 80 жилийн ойн хүрээнд Сүхбаатар аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн нийт албан хаагчид өөрсдийн хүч хөдөлмөрөөр 80 ширхэг мод суулган **УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС**-ийн төгөл бүтээн байгууллаа.



Сүхбаатар аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс нь “Хог хаягдлын тухай” хууль, Хүн амын эрүүл мэнд, хотын өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор хуваарьт газар болох Хүүхдийн тоглоомын талбайн ойр орчимын хог хаягдлыг цэвэрлэлээ.



3. Хүний нөөцийн чиглэлээр :

2020 оны жилийн эцсийн байдлаар хүний нөөцтэй холбоотой албан хаагчдыг томилсон, тэтгэмж, нэмэгдэл, урамшуулал олгосон тухай Б тушаал 17 гарсан.

Төрийн захиргааны 21 албан хаагчидтай төрийн жинхэнэ албан хаагчийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгуулан төлөвлөөний биелэлтийг жилийн эцсийн байдлаар татан авч дүгнэхэд бэлэн болгосон байна.

Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдын хувийн хэргийг тасаг бүрээр нэгтгэсэн байдлаар бүрдүүлсэн байсныг албан хаагч тус бүрээр нэгэн жигд өнгийн хавтас нээж стандартын дагуу хадгалж байна.

Ахмад настны хуулийн дагуу тус хэлтсээс өндөр насны тэтгэвэрт гарсан Ц.Буд, З.Ичинхорлоо нарт Монголын уламжлалт сар шинийн баярыг тохиолдуулан байгууллагын зүгээс тус бүр 30000, ахмадын өдрийг тохиолдуулан тус бүр 50000 төгрөгийн тэтгэмж олгосон.

Төрийн захиргааны албан тушаалын нэмэгдлийг 2020.07.01-ны өдрөөс эхлэн тооцон олгохоор шийдвэрлэсний дагуу аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн төрийн захиргааны албан хаагчдад шинээр олгох, ахиулан олгох зэрэг дэвийн судалгааг гарган УБЕГ-т хүргүүлсэний дагуу “Цалинг шинэчлэн тогтоох тухай” Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн Б/26 тоот тушаал гарсантай холбогдлуулан хэлтсийн даргын 2020 оны Б/02 тоот тушаалаар төрийн үйлчилгээний албан хаагчдад төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг зохих журмын дагуу олгогдож байна.

Мөн бүртгэлийн байгууллагын 80 жилийн ойн хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулагдахаар төлөвлөгдсөн Спортын арга хэмжээний хүрээнд тус хэлтсийн хуулийн этгээдийн улсын бүртгэгч Ц.Мөнхчимэг, угтах үйлчилгээний ажилтан О.Алтангэрэл нар нь Дорноговь болон Хэнтий аймгуудын баг тамирчидтай бэлтгэл хийхийн зэрэгцээ дээрх 2 аймгийн хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй танилцан туршлага судласан.



Коронавирус цар тахалтай тэмцэх, халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах зорилгоор улсын хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжин аж ахуй нэгж байгууллагууд ажлын тусгай горимд шилжин ажиллаж, ард иргэд, айл өрхийн орлого буурч хүндрэлтэй нөхцөл байдал үүсээд байгаа энэ үед тус хэлтэс нь албан хаагчдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор аймагт үйл ажиллагаа явуулж буй Талын гал ХК-тай хамтран галлагаатай гэр болон байшинд амьдардаг 8 албан хаагчдад тус бүр 2.5 тонн нүүрсний хөнгөлөлт үзүүлсэн.



Аймгийн Эрүүл мэндийн газар, Энэрэл өрхийн эмнэлэгтэй хамтран Коронавирусын ,халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах зорилгоор нийт 28 албан хаагчийг томуугийн эсрэг вакцинд хамрууллаа.



4. Сургалт, сурталчилгааны чиглэлээр :

2020 оны байдлаар УБЕГ болон орон нутгийн байгууллагуудаас 20 гаруй сургалтууд онлайнаар зохион байгуулагдаж оролцсон. Жишээлбэл

- Орон нутаг дахь бүртгэлийн байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй сэдэвт сургалт 2020.01.17
- Төрийн жинхэнэ албан албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй сэдэвт сургалт 2020.01.24
- Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчдад сонгуулийн хууль тогтоомжийг таниулах, зөвлөмж, чиглэл өгөх 2020.03.06
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарт зориулсан онлайн сургалт 2020.03.23
- Бүртгэлийн байгууллагын удирдах ажилтны цахим сургалт 2020.04.15-16
- Бичиг хэргийн ажилтнуудад зориулсан онлайн сургалт 2020.04.17
- Хуулийн этгээдийн улсын бүртгэгч нар зориулсан цахим сургалт 2020.04.30
- Хяналтын улсын байцаагч нарт зохион байгуулах сургалт 2020.05.06-08
- Орон нутаг дахь бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтантай гэрээ байгуулахад анхаарах асуудал, чиглэл өгөх сургалт 2020.05.15
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх цахим сургалт 2020.05.26
- Хүүхдийн эрх аюулгүй байдлыг хангах тухай онлайн сургалт 2020.07.27
- Аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас байгууллагын эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэл, арга зүй олгох сургалт 2020.09.16
- Аймгийн Засаг даргын Тамгын газраас Жендерийн эрх тэгш байдлын дүн шинжилгээ сэдэвт онлайн сургалт 2020.10.18



Дотооддоо сургалт зохион байгуулсан байдал:

Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтсээс Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Аймаг, нийслэл сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн сонгуулийн тухай хууль тогтоомжийг нэг мөр ойлгон хэрэгжүүлэх, санал авах өдөр сонгогчийн бүртгэлийг нягтлан шалгахтай холбоотой анхаарах асуудлуудын талаар Сүхбаатар аймгийн 13 сумдын улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан нарт цахим сургалтыг тус тус зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллав.

Уг сургалтуудаар ТЕГ-ын Сүхбаатар аймаг дахь хэлтсийн ахлах ажилтан, хошууч Б.Баярсайхан НУУЦЫН ТУХАЙ ХУУЛЬ /үүрэг, хариуцлага/ талаар заавар зөвлөгөө өгч ажилласан.



Мөн тус хэлтсийн бичиг хэрэг Г.Болор-Эрдэнэ нь хэлтсийн албан хаагчдад баримт бичгийн стандартаар хичээл бэлтгэн зөвлөмж хүргэлээ.



УБЕГ-ын Хамтын ажиллагаа сургалтын хэлтсээс нэг жилийн эрхтэй zoom программын эрх олгож өгсөнөөр сумдын улсын бүртгэгч нартай 7 хоног бүрийн 2 дахь өдөр хэлтсийн сонголыг цахимаар хуралдаж байна. Zoom программ ашигласанаар Улсын бүртгэлийн ерөнхий газар, хэлтэс, аймгийн гаргаж буй шийдвэрийг цаг алдалгүй бүгдэд хүргэн ажиллаж байна.



Монгол Улсын Их хурлын сонгууль, Аймаг, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн ээлжит сонгуульд сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх ажлуудыг төлөвлөгөөний дагуу ажилтнуудад хувиарлан бэлтгэл ажлыг хангаж, Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн удирдамжийн дагуу “сонгуулийн ирц бүртгэлийн программ”-ын сургалтыг УБЕГ-ын сургалтын багийн бүрэлдэхүүнтэй тусгай хөтөлбөр боловсруулан хамтран тус тус зохион байгуулж ажилласан.

Сургалт эхлэхээс 2 цагийн өмнө сургалтын танхимыг ариутган сургалтын өдрүүдэд сургалтад оролцож буй нийт албан хаагчид буюу итгэмжлэгдсэн ажилтнуудад коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилсан сэргийлэх зорилгоор амны хаалт заавал зүүсэн байх, гараа халдваргүйжүүлж байх, биеийн халууныг хэмжүүлэх зэрэгт онцгой анхаарч, танхимд идэх зүйл, ундаа, шингэн зүйлийг оруулах, тоног төхөөрөмжийн ойролцоо тавихыг хатуу хориглох зэрэг зөвлөмжийг өгч халууныг нь үзэж, халдваргүйжүүлэлтийг хийж ажилласан.



5. Хяналт, шалгалтын чиглэлээр :

Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай, Эд хөрөнгө эрхийн бүртгэлийн тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон бусад дүрэм журамын хэрэгжилтэнд хяналт тавихдаа Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2019 оны А/289 дугаар тушаалаар батлагдсан “Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журам”-ыг баримтлан чиг үүргийн дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Нэг. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр:

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр нийт 84 өргөдөл гомдол, хүсэлтийг хүлээн авч Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулинд заасан хугацаанд улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журмын 22 дугаар зүйлийн 22.1-ийг баримтлан улсын байцаагчийн 84 дүгнэлтээр иргэний улсын бүртгэлтэй холбоотой тодорхой нөхцөл байдлуудыг тогтоон иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэж ажиллалаа. Үүнд :

- Регистрийн дугаар өөрчилж дахин олгох-25
- Бүртгэл хийх тухай-25
- Бүртгэлд засвар, өөрчлөлт оруулах тухай-10
- Бүртгэл хүчингүй болгох тухай-20
- Бүртгэл сэргээх 4

Хаяж үрэгдүүлсэн, хүчинтэй байдлыг алдагдуулсан, дүр төрхийн өөрчлөлт орсон, овог нэр өөрчлөгдсөн, хаяг өөрчлөгдсөн үндэслэлээр 285 иргэний цахим үнэмлэхийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд хүчингүй болгосон.

Монгол Улсын 16 нас хүрсэн иргэн анх удаа иргэний үнэмлэх авах, 25, 45 нас хүрсэн иргэн иргэний үнэмлэхээ тогтоосон хугацаанд солиулаагүй Иргэний улсын бүртгэлийн 16 дугаар зүйлийн 16.5, 16.6-г тус тус зөрчиж тогтоосон хугацаанд иргэний үнэмлэхээ солиулах гэсэн үүргээ биелүүлээгүй зөрчлөө өөрийн биеэр мэдээлэн ирсэн 215 иргэний мэдээллийг хүлээн авч Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэж 6851000 / зургаан сая найман зуун тавин нэгэн мянган / төгрөгийн торгуулийн шийтгэл оногдуулж Улсын бүртгэлийн хэлтсийн 270000173167 дугаарын дансанд төвлөрүүлсэн байна.

Сүхбаатар аймгийн Прокурорын газраас 2020 оны 1 дүгээр улиралд хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн зөрчлийн материалыг хууль тогтоомжийн дагуу шалгаж шийдвэрлэсэн эсэхэд хяналт шалгалт хийж ажилласан.

Тайлангийн хугацаанд иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 785 бүртгэлд хяналт шалгалт хийсэн бөгөөд Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хяналт шалгалтын газраас ирүүлсэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйл, Монгол улсын Засгийн газрын 2018 оны 332 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам”-ын биелэлтэд хяналт тавьж ажиллах 2020 оны 01 сарын 16-ны өдрийн 8/409, 04 дүгээр сарын 08-ны өдрийн 8/3377, мөн 2020 оны 05 сарын 18-ны албан бичгүүдээр ирүүлсэн чиглэлийн дагуу төлөвлөгөөт бус 2 шалгалтын хүрээнд дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд

1. Иргэний шилжилт хөдөлгөөнийг 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс зогсоосонтой холбогдуулан 2019 оны 12 сарын 10-ны өдрөөс 2020 оны 01 сарын 31-ний өдрийн байдлаар өөр аймаг, хотоос ирсэн, сумаас сум хооронд, баг хооронд нийт 378 шилжилт хөдөлгөөний бүртгэлийг иргэний улсын бүртгэлийн цахим санд үнэн зөв, бүрэн бүртгэгдэж баталгаажсан эсэх, Монгол улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журмын 2 дугаар зүйлийн 2.1, 2.2-д заасан нотлох

баримт байгаа эсэхэд хяналт шалгалт хийхэд холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн зөрчил илрээгүй болно.

2. Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлд 2020 оны 01 сарын 09-ний өдрөөс хяналт тавьсан тайланг долоо хоног бүрийн 4 дэх өдрөөр тасалбар болгон хүргүүлэн ажилласан.

3. Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийн дэвтрийн бүртгэл, 2018 оны 22 бүртгэлийн дэвтрийн бүртгэл, 2019 оны 12 бүртгэлийн дэвтрийн бүртгэлийг иргэний улсын бүртгэлийн цахим санд нэг бүрчлэн тулган шалгаж үнэн зөв, бүрэн, хууль тогтоомжийн дагуу бүртгэгдсэн эсэхэд хяналт тавьж, шалгалт хийхэд илэрсэн алдаа зөрчил байхгүй болно.

4. Хяналтын байцаагчын зүгээс Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасан хугацаанд иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөний бүртгэлд байнгын хяналт тавьж ажилласан.

5. Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2020 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 8/7215 дугаартай албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийн дэвтэрт 2020 оны 06 дугаар сарын 25-ны өдрөөс 2020 оны 08 дугаар сарын 14-ний өдрийг дуустлах хугацаанд бүртгэгдсэн иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг, бүртгэлийн дэвтэрт үнэн зөв бүртгэгдсэн эсэх, ИУБ-22 маягтад бүртгүүлсэн иргэнээр гарын үсэг зуруулсан эсэх, нотлох баримтын бүрдүүлбэр хуульд заасан шаардлагыг хангасан эсэх, мэдээллийн санд бүрэн баталгаажсан эсэхэд хяналт тавьж, эд хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээний мэдээлэл нь эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд өмчлөгч мөн эсэхийг тулган шалгалаа. Шилжилт хөдөлгөөний сканейрдсан нотлох баримтыг “07 huanalt” хаягт 7 хоног бүр байршуулан ажиллаа.

Улсын бүртгэлийн байгууллагаас Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөний дагуу дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллалаа. Үүнд :

Улсын Их хурлын ээлжилт сонгууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу 67 хэсгийн хорооны сонгогчийн нэрийн жагсаалтыг хуульд заасан хугацаанд үнэн зөв хэвлэн хэсгийн хороонд хүргүүлэх үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаа.

Сонгуулийн тухай хуулийг зөрчиж хуульд зааснаас бусад тохиолдолд сонгогчийн нэрийн жагсаалтыг олшруулсан, эсхүл тараасан зөрчил гараагүй болно.

- ❖ 2020 оны 05 сарын 28-ны өдөр сонгогчдын нэрийн жагсаалтыг хэсэг тус бүрээр хэвлэх үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан.
- ❖ 2020 оны 05 сарын 29-ны өдөр сумдын хэсгийн хороодод сонгогчдын нэрийн жагсаалтыг акт үйлдэн хүлээлгэн өгсөн.
- ❖ 2020 оны 06 сарын 02-ны өдөр сонгуулийн үйл ажиллагаанд шаардлагатай бараа материал, тоног төхөөрөмжийг УБЕГ-аас татан авах үйл ажиллагааг Тагнуулын байгууллага болон Цагдаагийн байгууллагатай хамтран зохион байгуулсан.
- ❖ Хяналт шалгалтын газраас ирүүлсэн 2020 оны 05 сарын 28-ны өдрийн чиглэлийн дагуу 2020 оны 06 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн 2020 оны 06 дугаар сарын

10-ны өдрийн ажлын цагт багтаан нийт 889 сонгогч шилжих бүртгэлийг хуулийн дагуу холбогдох нотлох баримтыг үндэслэн бүртгэсэн эсэх сонгогчдын нэрийн жагсаалтанд өөрчлөлт оруулах лавлагааг хуулийн дагуу үнэн зөв хэвлэсэн эсэхэд хяналт тавьж тэмдэглэн хөтлөн мэдээг ирүүлсэн загварын дагуу хяналт шалгалтын газарт хүргүүлэн ажилласан.

2020 оны 10 дугаар сарын 02-ны өдөр Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн 67 хэсгийн хорооны сонгогчийн нэрийн жагсаалтыг үнэн зөв хэвлэх, Аймгийн сонгуулийн хороонд сонгогчийн нэрийн жагсаалтыг хүлээлгэн өгөхөд хяналт тавьж ажиллаа. 2020 оны 10 дугаар сарын 15-ны өдөр сонгуулийн ирцийн мэдээг тогтоосон цагт авч ажилласан.

Сонгуулийн тухай хуульд зааснаас бусад тохиолдолд сонгогчийн нэрийн жагсаалтыг олшруулсан, эсхүл тараасан зөрчил гараагүй болно

Зөрчлийн тухай хуулиар торгуулийн арга хэмжээ авагдсан иргэнд Иргэний улсын бүртгэлийн тухай хууль болон Засгийн газрын 396 дугаар тогтоолоор батлагдсан “Иргэний үнэмлэхийн дүрэм”-ийг тайлбарлан иргэний үнэмлэхээ хаяж үрэгдүүлэх, гэмтээхгүй мөн тогтоосон хугацаанд иргэний улсын бүртгэлд бүртгүүлэх ёстойг тайлбарлан ажиллаж байна.

Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Засгийн газрын 396 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол улсын иргэний үнэмлэхийн дүрэм”, Зөрчлийн тухай хуулийн 15.24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол улсын стандарт MNS 5274:2017 нийтлэг шаардлагад заасны дагуу мэдээлэл бэлтгэн Баруун-Урт сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэн явуулдаг 7 барьцаалан зээлдүүлэх газарт тайлбарлан таниуллаа. 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр сумдын улсын бүртгэгч нарт Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн чиглэлийн дагуу иргэний шилжилт хөдөлгөөний талаарх онлайн сургалт хийв.

Хөдөө орон нутаг болон бусад газраас утсаар холбогдсон иргэнд улсын бүртгэлийн талаарх зөвөлгөө мэдээлэл өгч ажиллаж байна. Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журамд заасны дагуу иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэл, улсын бүртгэлийн архивын чиглэлээр нийт 645 бүртгэлд байнгын болон түүвэрчилсэн хяналтыг хийсэн байна. Биеийн давхцахгүй өгөдлөлийн бүртгэлийг алдаатай хөтөлсөн улсын бүртгэгч нарын бүртгэлийг хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр залруулав.

Шалгалтаар илэрсэн зөрчлийг тухай бүр нь арилгуулах арга хэмжээг авч, улсын бүртгэгч нарт заавар зөвлөмж өгч гаргасан зөрчлийг дахин гаргахгүй байхыг анхааруулан ажиллаж байна.

Хоёр. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр :

Тус хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасаг нь тайлант хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль, Улсын тэмдэгтийн тухай хууль, Газрын тухай хууль, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Татварын ерөнхий хууль, Иргэний хууль, нотариатын тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, УБЕГ-аас ирүүлсэн чиглэл, журмын хүрээнд эд хөрөнгийн эрхийн

бүртгэлийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэж нийт мэдүүлэг хүлээн авч ажилласан.

Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2019.07.03-ны А/685 дугаар тушаалаар батлагдсан “Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандарт”, 2019.01.23-ний өдрийн засгийн газрын тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Шинээр батлагдан гарсан хууль, тогтоомж болон цаг үеийн үйл ажиллагаатай холбогдуулан Улсын бүртгэлийн ерөнхий газар, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн чиглэл, дүрэм журмуудыг уншиж судлан хэрэгжилтийг ханган холбогдох ажлуудыг зохион байгуулсан.

Хэлтсийн даргын баталсан 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн удирдамжийн дагуу эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч бүртгэлийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт шалгалтыг хийлээ. Шалгалтаар эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарын 2019 оны 1 дүгээр сарын 01-с 2019 оны 06 сарын 31-ны өдрийг дуустал нийт 7898 бүртгэлийг архивын хувийн хэрэг дэх цаасан нотлох баримт болон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн сан дахь мэдээлэлтэй тулган шалгалаа. Шалгалтаар дараах зөрчлүүд илэрлээ.Үүнд:

- ❖ Улсын бүртгэлд бүртгэгдсэн газар эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн хувийн хэргийг бүртгэл хийснээс хойш ажлын 1 хоногийн дотор архивт хүлээлгэн өгөөгүй зөрчил
- ❖ Нотлох баримт дутуу авч бүртгэл хөтөлсөн зөрчил-1
- ❖ Нэгж талбарын дугаар зөрүүтэй байхад болон нотлох баримтууд нь зөрүүтэй байхад бүртгэл хөтөлсөн зөрчил-1

Шалгалтаар илэрсэн зөрчлүүдийг арилгуулах зорилгоор 2020 оны 06 сарын 05-ны өдрийн Хяналтын улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлэн ажиллалаа.

Тайлангийн хугацаанд 175 бүртгэлд байнгын болон түүвэрчилсэн хяналт шалгалт хийснээс илэрсэн зөрчилгүй болно.

Эд хөрөнгийн бүртгэлийн мэдээллийн санд мэдээлэл тусгагдаагүй болон зөрүүтэй тусгагдсаныг залруулах зорилгоор эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгчдээс гаргасан хүсэлтийг хүлээн авч хяналтын улсын байцаагчийн 25 дүгнэлт гаргаж улсын бүртгэгч нарт хүлээлгэн өгсөн.

УБЕГ-ын даргын 2020 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн А/1172 дугаар тушаалаар Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хаяж үрэгдүүлсэн тохиолдолд хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр гэрчилгээг хүчингүйд тооцож байхаар шийдвэрлэсний дагуу Хяналт шалгалтын газраас 2020 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 8/7219 дугаартай албан бичгээр ирүүлсэн чиглэлийг мөрдлөг болгон хэрэгжүүлж тайлант хугацаанд нийт 10 иргэний гаргасан мэдүүлэг, холбогдох нотлох баримтыг хүлээн авч шалган, гэрчилгээг хүчингүйд тооцох тухай 10 дүгнэлт үйлдэж эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасагт шилжүүлэн хяналт тавьж ажилласан байна.

[Гурав. Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр:](#)

Хуулийн этгээдийн 96 бүртгэлд байнгын болон түүвэрчилсэн хяналт тавьж ажиллалаа.

Зөрчлөө илчлэн мэдээлсэн 1 хуулийн этгээдийн гомдлыг хүлээн авч Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзан шийдвэрлэсэн.

Бусад зохион байгуулсан ажлууд:

Ажлын тусгай горимд шилжин ажиллах тухай” Хэлтсийн даргын 2020.02.14-ний өдрийн А/09 дугаар тушаалын дагуу нийт албан хаагчид онцгой байдал зарласан хугацаанд улсын онцгой байдлын дүрэм журам зааврыг мөрдөн ажиллаж байна. Үйлчилгээний зааланд байнгын гар ариутгагч байршуулан, амны хаалтыг тогтмол хэрэглэж хэвшсэн. Угтах үйлчилгээний ажилтанг ажиллуулж иргэдэд бүртгэл болон онцгой дэглэмийн талаар зөвлөгөө өгч ажиллаж байна.

УБЕГ-аас зохион байгуулсан “Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах нь” сэдэвт сургалт, Хяналт шалгалтын газраас зохион байгуулсан 6 удаагийн онлайн сургалтууд, Иргэний улсын бүртгэл ба сонгогчийн бүртгэл, Сонгогчийн нэрсийн жагсаалт үйлдэх, танилцуулахтай холбоотой сургалт, Сонгуулийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй холбоотой онлайн хурал, Бичиг баримт үнэт цаасны хадгалалт, хамгаалалт, Кибер гэмт хэргийн тухай сэдэвт онлайн сургалтууд, Итгэмжлэгдсэн ажилтан, улсын бүртгэгч нарт зориулсан сургалт, 2020 оны 05 сарын 06-08, 13-15-ны өдрүүдэд Хяналт шалгалтын газраас зохион байгуулсан “улсын байцаагчийн үйлдэж буй дүгнэлтийн талаарх”, 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” онлайн сургалт, 2020 оны 06 сарын 10-11-ний өдрүүдэд Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд итгэмжлэгдсэн ажилтны сургалт болон сонгогчдын нэрийн жагсаалтад орсон өөрчлөлт болон нэрийн жагсаалтыг хэвлэх анхаарах тухай танхимын сургалт, 2020 оны 04 дугаар сарын 19-ны өдөр Аймгийн Прокурорын газрын “Зөрчлийн тухай хуулийн 17 дугаарт бүлэгт зөрчлийн талаарх зохицуулалт, анхаарах асуудал” сургалт, 2020 оны 04 сарын 08-ны өдөр УБЕГ-аас зохион байгуулсан сонгуулийн тухай онлайн сургалтанд тус тус хамрагдан Монгол улсын сонгуулийн тухай хууль, УБЕГ-ын даргын А/372 тушаалаар батлагдсан сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, сонгогч шилжих журмыг мөрдлөг болгон ажилласан.

6. Иргэний бүртгэлийн чиглэлээр :

Тус онд Монгол улсын УИХ-ын сонгууль, Орон нутгийн ИТХ-ын сонгуулийн жилтэй холбогдуулан УБЕГ-аас баталсан “Сонгуулийн хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тусгагдсаны дагуу төлөвлөсөн ажлуудаа хуульд заасан хугацаанд бүрэн хэрэгжүүлж дуусгалаа. Үүнд :

1. Төлөвлөгөөний дагуу Аймгийн 13 сумдын ИТХ-ын хэсэг байгуулсан тухай тогтоолыг хүлээн авч, election.gazar.mn системд хэсгийн мэдээлэл, нутаг, дэвсгэр, санал авах байрны мэдээллийг оруулж хуулийн хугацаанд бүртгэсэн.

2. Election.gazar.mn системд хэсэг оноогдоогүй иргэнд хэсгийг бүрэн оноож, 13 сумдын хаягийн мэдээллийг санал авах байрны мэдээлэлд бүрэн оруулж дуусгасан.

3. УИХ-ын Сонгогчдын нэрсийн жагсаалтыг эхний байдлаар хэвлэх эрхийг Иргэний бүртгэлийн улсын ахлах бүртгэгч, 2 улсын бүртгэгч нар дээр нээж, 01-64 дугаар бүхий нийт 64 хэсгийн 40695 сонгогчдын нэрийн жагсаалтыг 2020.05.28-ны өдөр хэсэг тус бүрээр 3 хувь хэвлэж, 1 хувийг итгэмжлэгдсэн ажилтанд, 1 хувийг 13 сумын 64 хэсгийн хороодод хэлтсээс томилогдсон ажлын хэсэг тус тус хүргэн өгч, 1 хувийг улсын бүртгэлийн хэлтэст хадгалсан.

4. Их хурлын сонгуулийн тухай хуулийн 24 дугаар зүйлд заасны дагуу “Сонгогчийн шилжилт хөдөлгөөнийг санал авах өдрөөс 14-өөс доошгүй хонгийн өмнө сонгогч шилжих хүсэлтийг хүлээн авна” гэж заасны дагуу аймгийн хэмжээнд нийт 889 лавлагаа сүлжээнд бүртгэгдсэнээс сонгогч шилжин явсан 420, сонгогч шилжин ирсэн 459, нас баралт 6, төлөв сэргээсэн 3, иргэний бүртгэлтэй холбоотой өөрчлөлт 1 тус тус бүртгэсэн байна.

5. Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн хөтөлбөрийн дагуу “Сонгуулийн ирц бүртгэлийн программ”-ын сургалтад УБЕГ-ын сургалтын багийн бүрэлдэхүүн, УБХ-ийн албан хаагчид, 13 сумын 64 итгэмжлэгдсэн ажилтнууд хамрагдсан сургалтыг 2020.06.12-13ны өдрүүдэд амжилттай зохион байгуулсан.

6. Аймгийн хэмжээнд нийт 889 лавлагаа хэвлэгдсэнийг ирц бүртгэлийн программын сургалтан дээр хэсгийн итгэмжлэгдсэн ажилтанаар хяналтын улсын байцаагч, улсын бүртгэгч нарын хяналтан дор хэсэг тус бүрээр шивж алдаагүй бүртгэхэд анхаарч ажиллаа.

2020 оны 10 дугаар сарын 15-ны өдөр явагдсан Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн нэрсийн жагсаалтыг бэлтгэх хүргүүлэх ажлын хүрээнд :

1. Eelection.gasr.mn програмд нэвтрэх эрхийг иргэний бүртгэлийн тасгийн улсын ахлах бүртгэгч, улсын бүртгэгч нийт 3 албан хаагчидад нээж сонгогчийн санал авах байрны мэдээллийг 13 сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоолыг үндэслэн бүртгэж, нийт аймгийн хэмжээнд 67 хэсгийн мэдээллийг программд бүртгэсэн. 13 сумын ИТХ-ын тогтоолыг PDF өргөтгөлтэй болгож Eelection.gasr.mn хаягны Сонгууль цэсний Хурлын тогтоол нэртэй цэсэнд бүртгэж зурган хэлбэрээр орууллаа.

2. Аймгийн хэмжээнд 67 хэсгийн 6294 хаяг бүртгэгдсэн бөгөөд үүнээс аймгийн төв баруун-урт суманд 9 багийн 5049, бусад 12 сумданд 1245 хаягийн мэдээллэл бүрэн орж, мэдээллийн санд буюу санал авах байранд бүртгэгдээгүй хаягийн жагсаалтанд хаяг орхигдоогүй, бүх мэдээллийг ИТХ-ын тогтоолтой тулган шалгаж, баталгаажуулж дуусгасан болно.

3. Сүхбаатар аймгийн хэмжээнд аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд улсын бүртгэлийн байгууллагын хийж гүйцэтгэх ажил үйлчилгээ, итгэмжлэгдсэн ажилтнуудад сонгуулийн өдөр хэрхэн ажиллах, тоног төхөөрөмж, программыг яаж ашиглах талаар мэдээлэл, сургалтыг 2020.10.04-ний өдөр Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын хурлын танхимд зохион байгуулсан.

4. СНЖ-ыг цахим сангаас сонгогчийн хувийн мэдээллийн нягтлан шалгах, программаас сонгогчдын нэрийн жагсаалтыг хэвлэх, баталгаажуулах ажлыг хийж гүйцэтгэсний дараа СНЖ-ыг Акт үйлдэн түгжих, битүүмжлэн лацдах ажлыг зохион байгуулж ажиллалаа. Сонгуулийн хуулийг хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний дагуу хийгдэж байгаа ажлуудын талаарх илтгэх хуудасыг тухай бүр УБЕГ-т тайлагнан, УИХ, ИТХ-ын сонгуулийн өдөр аймгийн хэмжээнд дэх нийт хэсгүүдийн ирц бүртгэлийн мэдээ нэгтгэн УБЕГ-т хүргүүлж ажиллаа.



Иргэний бүртгэлийн чиглэлээр Гадаадад зорчих эрхийн бүртгэлийн чиглэлээр гадаад паспортыг шинээр 304 иргэнд, гадаад паспортын хүчингүй болгосны бүртгэл 70, иргэний цахим үнэмлэхний лавлагаа 902, бусад лавлагаа 1422, хууль хяналтын байгууллагад иргэний цахим үнэмлэхний 84 лавлагаа тус тус олгосон байна.

Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл 2020 оны УИХ-ын сонгуультай холбогдуулан 2020 оны 02 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн зогссонтой холбогдуулан 2019 оны 12 сарын 01-ээс 2020 оны 01 дүгээр сарын 31 хүртлэх 378 иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийн анхан шатны материалд хяналтын улсын байцаагчтай хамтран бүрдүүлэх материалын үнэн зөв, бүрдэл бүрэн эсэхийг шалгаж ажилласан.


Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тайлангаа сар бүрийн 27-ны өдөр 13 сум, хэлтсийн улсын бүртгэгч нарын хэмжээнд нэгтгэн УБЕГ-ын Улсын бүртгэгч Ж.Нарантуяад j.narantuya@burtgel.gov.mn хаягаар, иргэний бүртгэлийн чиглэлээр олгосон лавлагааны мэдээг сар бүрийн 26-ны өдөр 13 сум, хэлтсийн улсын бүртгэгч нарын хэмжээнд нэгтгэн Иргэний бүртгэлийн нэгдсэн архивын ахлах мэргэжилтэн Т.Байгальмаад t.baigalmaa@burtgel.gov.mn хаягаар тус тус хүргүүлэн ажиллаж байна.

Иргэний бүртгэлийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тоон мэдээгээр аймгийн хэмжээнд нэгтгэвэл:

- ✚ төрсний бүртгэлд 1349 хүүхэд бүртгүүлснээс 730 нь эрэгтэй, 319 нь эмэгтэй,
- ✚ гэрлэлтийн бүртгэл 301
- ✚ гэрлэлт дуусгавар болсоны бүртгэл 47
- ✚ Монгол улсын иргэнд хүүхэд үрчлэлтийн бүртгэл 30
- ✚ Эцэг тогтоолтын бүртгэл 59
- ✚ Ургийн овог, эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэрээ сольсоны бүртгэл 59
- ✚ Нас барсны бүртгэл 357
- ✚ 16 нас хүрч иргэний үнэмлэхээ захиалсан бүртгэл 910
- ✚ Иргэний үнэмлэхний дахин олголт 244
- ✚ Иргэний үнэмлэхний 25,45 насны сунгалт 1463
- ✚ Үндэсний энгийн гадаад паспорт захиалга 277
- ✚ БНХАУ-д зорчих нэг удаагийн үнэмлэх олголт 97
- ✚ БНХАУ-д зорчих олон удаагийн үнэмлэх олголт 66
- ✚ Аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн 344

Иргэний бүртгэлийн чиглэлээр олгосон лавлагаа :

- ✚ Албан хэрэгцээнд 2474
- ✚ Хууль хяналтын байгууллагад 146
- ✚ Иргэнд 3111
- ✚ Төрийн болон төрийн бусад байгууллагад 171 лавлагаа мэдээлэл өгсөн байна.



7. Иргэний бүртгэлийн архив, мэдээлэл технологийн чиглэлээр :

Иргэний баримтын архивын үндсэн ажлын хувьд 2020 онд нийт 7143 маягт архивт орж ирснийг галиглан холбогдох санд нь байршуулсан. Бусад аймаг нийслэлээс 489 иргэн, 206 хүүхдийн хувийн хэрэг ирснийг галиглан хувийн хэргийн санд байршуулж, 192 иргэн, 46 хүүхдийн хувийн хэргийг бусад аймаг, нийслэл рүү хүргүүлэв.

2527 биеийн давхцахгүй өгөгдөл маягт, 228-ш CD сумдаас хүлээн авч УБЕГ луу мэдээллийг онлайнаар хүргүүлэв. Монгол улсын Хууль зүйн сайдын 2015.09.02-ны өдрийн А/193 тоот тушаалаар батлагдсан «Иргэний улсын бүртгэл хөтлөх журам»-ыг үндэслэн иргэний улсын бүртгэл хөтөлсөн биеийн давхцахгүй өгөгдлийн шинээр бөртгэсэн ИУБ-31 маягтын А талыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын иргэний бүртгэлийн асуудал хариуцсан нэгжид, иргэний үнэмлэхний хугацаа сунгалт ИУБ-31 маягтын А талыг Улсын бүртгэлийн төв архивын Иргэний баримтын архивт нэрийн үсгийн эхээр галиглан, дагалдах хуудсын хамт хүргүүлж байна.

ИУБ-22 санд шинээр 1187-ш, Иргэний үнэмлэх дахин авах өргөдөл санд 236-ш, иргэний үнэмлэх олголтын ИУБ-21 санд 2198-ш тус тус байршуулав.

Архивын фондоос татан авч шалгасан нэгж нийт 9904-ш. Сар болгоны 25-ны өдрөөр тасалбар болгон мэдээ тайлангаа тогтмол гаргаж өгч байна.

Шинээр цахим үнэмлэх авах 2003-2004 оны 150-ш ИУБ-11 маягтуудыг программд шалгаж өөр аймаг, хотод ИШБ-д хамрагдсан 59-ш ИУБ-11 маягтуудыг тухайн аймаг, хотод шилжүүлэв. 67 иргэний 11 маягтуудыг хувийн хэргийн санд байршуулж, 24 иргэнийг ИШБ-д хамруулахыг сумдын бүртгэгч нарт мэдэгдэж, жагсаалтаар нэрсийг хүргүүлэв. Нөхөн бүртгэлээр 6 иргэний хувийн хэргийг /ИУБ-11, ИУБ-12, ИУБ-15/ маягтуудыг журнал хувийн хэргийн лавлагааг үндэслэн иргэний улсын бүртгэгчээр бүрдүүлэн хувийн хэрэгт байршуулсан.

Архивын фондод баримтын жижиг бор 712 хавтасны дугаарлалт дутуу байсныг дахин шинээр бичиж цэгцлэх үйл ажиллагааг давхар хийж гүйцэтгэлээ.



Улсын бүртгэлийн салбарын үйл ажиллагааны явцад бий болсон баримт бичгийн хадгалах хугацааны жагсаалтаар хадгалах хугацаа нь дууссан хадгаламжийн нэгж буюу хуудас баримт бичгүүдийг хэлтсийн дэргэдэх комиссын хурлаар хэлэлцэж баталсан шийдвэрийн дагуу 2019-12-31ний өдөр хүртэлх баримт бичгийн хадгалах хугацааны жагсаалтаар хадгалах хугацаа нь дууссан хадгаламжийн нэгжийн жагсаалтыг бүрэн гүйцэт тоолон хадгалах хугацааны нэрийн жагсаалт үйлдэн устгах саналыг дээд шатны байгууллагад хүргүүлсэн.

УБНА, Аймаг, Нийслэлийн газар хэлтсийн устгах баримт бичгийн жагсаалт 2020.09.24

| д/д | Аймаг | ИУБ-22 маягт СЖ-24 /1жил/ | ХААТР 23, 24 маягт СЖ-24 /1жил/ | Мэдээллийн санд баталгаажуулсан бүртгэлийн дэвтэр СЖ-29 /10 жил/ | ИГББ-ийн лавлагаа и/у дахин олголтын анкет СЖ-32 /3 жил/ | ИУБ-21 маягт А,Б тал СЖ-34 /1жил/ | Хүчингүй болсон Г.П мэдүүлгийн хуудас, хил нэвтрэх үнэмлэх СЖ-35 | Хүчингүй болсон иргэний цахим үнэмлэх, ТГ, СЖ-35 /1 жил/ | Мэдээний дагалдах хуудас СЖ-37 /1жил/ | НИЙТ |
|-----|------------------------|---------------------------|---------------------------------|--|--|-----------------------------------|--|--|---------------------------------------|------|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 |
| 15 | Сүхбаатар | 2019 | | | 2017 | | 2019 | | 2019 | |
| | Он | | | | | | | | | |
| | Хадгаламжийн нэгж | | | | | | | | | |
| | Хуудсаар | | | | | | | | | |
| | ХААТР, маягт ширхэгээр | 1305 | | | 513 | 2822 | 96 | | 798 | 5534 |

Жагсаалт гаргасан: Архивч

А.Одбаяр

Хадгалах хугацааны жагсаалтаар хадгалах хугацаа нь дууссан хадгаламжийн нэгж буюу 6808 хуудас баримт бичгүүдийг 2019-09-21 өдөр устган акт үйлдэн баталгаажуулж дээд шатны байгууллагад хүргүүлсэн

БҮРЭН УСТГАСАН БАЙДАЛ



Бусад ажил үйлчилгээ:

Бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 80 жилийн ойн хүрээнд төлөвлөгдсөн ажлын хүрээнд зарим сумдад дараах ажлуудыг улсын бүртгэгч нартай хамтран зохион байгуулан ажиллаа. Уулбаян суманд нийгмийн даатгалын байцаагчтай хамтран аж ахуйн нэгжүүд, соёлын төв, эргэлтийн эмийн сан, хаан банк, төрийн банк, эрчим хүч, шуудан холбоо, цаг уур зэрэг 18 байгууллагад байгууллагын танилцуулга, иргэний бүртгэлийн чиглэлээр мэдээлэл өгч ажиллалаа. Сургалтанд суусан иргэний мэдээллийг бататгах зорилгоор “Алтан хонх” тэмцээн зохион байгуулж, Дурсамж, мөнгөн шагналаар шагнав.



Эрдэнэцагаан сумын улсын бүртгэгчтэй хамтран 80 жилийн ойн арга хэмжээний хүрээнд 2020 оны 11 сард Сумын Соёлын төв, Цагдаагийн тасагтай хамтран Монгол улсын лекторуудын холбооны тэргүүн гэр бүл судлаач Ж.Баясгаланг урилгаар авчирч албан хаагчид, эцэг эхчүүдэд зориулан ГЭР БҮЛИЙН ҮНЭ ЦЭНЭ сэдэвт лекц, ЕБСургуулийн ахлах ангийн сурагчдад зориулсан ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ЗОХИСТОЙ

ХЭРЭГЛЭЭ, ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ сэдэвт лекцийг 2 үе шаттай зохион байгуулж ажиллалаа. Тус лекцэнд 120 эцэг эх, 346 сурагч, 54 албан хаагчид хамрагдсан.


Мөн Төрийн 6 байгууллагын дарга эрхлэгч, ЗДТГ-н 22 албан хаагчид 1 удаагийн сургалтыг зохион байгуулж, иргэдэд гарын авлага Иргэний бүртгэлийн мэдээ мэдээллийг түгээж ажиллалаа.



Азийн хөгжлийн банкны Ухаалаг засаг төслийн хүрээнд Эрдэнэцагаан, Баяндэлгэр сумдуудад нөүтбүүкийг иж бүрнээр шинэчилж civilreg болон оффлайн системийг нэвтрүүлсэн. Тус төслийн хүрээнд Сүхбаатар аймгийн Наран сум нь өвлийн байрны асуудалтай Улсын бүртгэлийн нэгдсэн сүлжээнд холбогдоогүй байсныг шинээр нэвтрүүлэн оруулав. Бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэж байна.

Түвшинширээ, Уулбаян сумдын Улсын бүртгэгч нар нь шинэ өрөөнд нүүн орж бүртгэлийн нэгдсэн сүлжээг зөөж хэвийн үйл ажиллагаанд оруулав. Хэлтэсээс зохион байгуулсан үйл ажиллагаа болон УБЕГазраас зохион байгуулсан мэдээ мэдээллийг цаг тухай бүрт нь www.su.burtgel.gov.mn www.facebook.com/suburtgel гэсэн цахим хуудаснаа нийтлэн ажиллаж байна.

УБЕГ-ын Мэдээлэл технологийн газраас ирсэн чиглэлийн дагуу 13 сумын оффлайн санд цаг тухай бүрт шинэчлэгдсэн программ update-ийг шинэчлэл хийн ажилласан.



УБЕГ-ын Мэдээлэл технологийн газраас ирсэн чиглэлийн дагуу 13 сумын оффлайн санд цаг тухай бүрт шинэчлэгдсэн программ update-ийг шинэчлэл хийн ажилласан. Сүхбаатар сумын Улсын бүртгэгч Н.Нямжаргалын нөүтбүүкний гэмтэж ажиллахгүй болсоныг шинээр сольж хэвийн ажиллагаатай болгосон. Түмэнцогт сумын Улсын бүртгэгч Нандинцэцэгийн нөүтбүүкний цэнэглэгч гэмтэж ажиллахгүй болсоныг шинээр сольж хэвийн ажиллагаатай болгосон. Онгон сумын бүртгэгч Х.Ганзоригийн нөүтбүүкний HARD

disk гэмтэж ажиллахгүй болсныг шинээр HARD суурьлуулан хэвийн ажиллагаатай болгосон.

Баяндэлгэр сумын бүртгэгч Ж.Должинсүрэнгийн компьютер вирүстэж бүртгэл хийх боломжгүй болсон тул форматлаж шинээр вирүсний программ суулгасан.

Эрдэнэцагаан сумын бүртгэгч Ц.Содцэцэгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хэлтсийн нөөц боломжоор бүрэн сольж өгсөн. Хэлтсийн нийт 7 суурин компьютерийн үйлдлийн систем гэмтсэнийг форматлан, вирусны программ суулган хэвийн үйл ажиллагаанд оруулан ажилласан.УБЕГ-аас зохион байгуулж буй онлайн сургалтыг zoom application.ээр нэвтэрч сургалтанд хамрагдах нөхцөл боломцоог ханган ажиллаж байна. Улиралд дундажаар 2-3 удаа хэлтсийн албан хаагчдын суурин болон зөөврийн компьютеруудын тоос тоосонцорыг цэвэрлэн ажиллаж байна.

Мэдээллийн ил тод байдлын хүрээнд хэлтсийн вэб сайт дээр заавал байрлавал зохих мэдээллүүдийг бүрэн байршуулсан талаар тайланг Хяналт шинжилгээ үнэлгээний газар хүргүүлсэн.

Сүхбаатар аймгийн Албан ёсны сайт www.sukhbaatar.mn сайтад шинэ мэдээ мэдээлэл тогтмол байршуулан ажиллаж байна.

Хэлтсийн дотоод сүлжээний аюулгүй байдлыг хангах хүрээнд илүү ашиглах шаардлагагүй сүлжээний кабел утсуудыг цэгцэлж, шинээр ил гарсан утсуудыг далдалсан.

Хэлтсийн бүртгэлийн ерөнхий сүлжээ нь Мэдээлэл холбоо сүлжээ ТӨК-ын сүлжээгээр хангагдаж ажиллагааг бүрэн ханган ажиллаж байна.

Серверийн өрөөний аюулгүй байдлыг хангах хүрээнд давхар шилэн хаалт байршуулсан. Тухайн өрөөний цэвэрлэгээг тогтмол хэлтсийн үйлчлэгтэй хамтран хийж байна. Мөн Улаанбаатар хотоос шинээр тог тогтворжуулагч төхөөрөмж худалдан авч суурьлуулсан.



Цахим мэдээллийн санд мэдээлэл хүлээн авах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах журмын хэрэгжилтийг хангах хүрээнд хэлтсийн албан хаагчидад Мэдээлэл

технологийн зөвлөмж зөвлөгөөг тогтмол танилцуулж хэрэгжилтийг хянан ажиллаж байна.

Иргэний бүртгэл эд хөрөнгийн бүртгэл хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой тоон мэдээг бэлтгэн хэлтсийн цахим хуудас болон Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс гэсэн фэсбүүк хуудсанд нийтлэн ажиллаж байна.

8. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр :

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг нь 2020 оны жилийн эцсийн байдлаар дараах үйлчилгээг үзүүллээ. Эд хөрөнгийн, хуулийн этгээд бүртгэлийн чиглэлээр 9500 иргэн аж ахуй нэгжид зөвлөгөө зөвлөмж өгсөн байна.

Иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй үйлчлэх үүднээс газар өмчлөх эрх болон газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн бүртгэлийн материалыг сумдын бүртгэгч нараар дамжуулан хүлээн авч ажиллаж байна.

Тус аймагт үйл ажиллагаа явуулж байгаа банк болон банк бус санхүүгийн байгууллагууд болон нотариатч нарт эд хөрөнгийн бүртгэл, хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль болон шинэчлэгдэн гарсан хууль, журмын талаар мэдээлэл хийж гарын авлага тарааж заавар, зөвлөгөө өгсөн.

Дундын мэдээллийн сангаар дамжуулан 461 иргэн, аж ахуй нэгж, байгууллага газар эзэмших, ашиглах эрхээ улсын бүртгэлд бүртгүүлсэн.

Төрөөс үнэгүй хувьчилсан газрын анхны бүртгэл нийт 273 бүртгэгдсэн.

Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн анхны бүртгэлд: 319

- Худалдах гэрээ: 264
- Бэлэглэх гэрээ: 112
- Гэрээслэл, өв залгамжлах гэрээ: 52
- Арилжих гэрээ: 2
- Хамран өмчлөгч өөрчлөх: 43
- Шүүхийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдөх: 8
- Лавлагаа: 207
- Барьцаа гэрээ: 1278
- Бүртгэлд өөрчлөлт оруулах: 88
- Үрэгдүүлсэн гэрчилгээ: 14
- Барьцааны гэрээ дуусгавар болгох: 1027
- Хувийн хэрэг хаах: 3
- Үйлчилгээний хураамж: 43964167 төгрөг
- Татварын орлого: 98889370 төгрөг

Нийт: 3875 мэдүүлэг хүлээн авч хувийн хэрэгт баяжилтийг хийж ажилласан.

Архивт нийтдээ 14149 хувийн хэрэг хадгалагдаж байна.

Сумдын бүртгэгчээр дамжуулан эд хөрөнгийн 287 бүртгэл хийсэн.

Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөхтэй холбоотой 183 баримт бичиг, Газар өмчлөхтэй холбоотой 208 баримт бичиг хүлээн авч бүртгэл хийсэн. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт сар болгоны 25-ны өдөр мэдээгээ хүргүүлж байна. Цар тахал гарсантай холбоотойгоор 2020 оны 11 сарын 11-нээс 12 сарын 01 хооронд иргэдэд үзүүлэх үйлчилгээ бүрэн зогссон. Иргэдэд e.mongolia.mn, burtgel.gov.mn www.su.burtgel.gov.mn. e.mongolia.mn хаягаар лавлагаа мэдээллийг иргэд болон ААНБ-д олгосон.

9. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр :

Улсын бүртгэлийн ерөнхий хууль болон түүнийг дагалдан гарсан журмууд, 2020 оны 01 дүгээр сарын 01-нээс мөрдөгдөхөөр батлагдсан татварын багц хуулийн шинэчилсэн найруулга, дагалдан гарсан журмууд, ХЭБГ болон ХШГ-аас ирүүлсэн чиглэл, зөвлөмжүүдийг бүртгэл хөтлөх үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

2020 онд иргэн, хуулийн этгээдээс 677 өргөдөл хүсэлт хүлээн авч, зөвлөгөө өгч шийдвэрлэсэн.

Шинээр байгуулагдсан хуулийн этгээд 60 бүртгэгдсэнээс:

| | |
|-------------------|---|
| ХХК | 49 |
| Холбоо | 8 |
| Нөхөрлөл | 1 |
| Шашны байгууллага | 2 тус тус улсын бүртгэлд бүртгүүлсэн байна. |

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018.11.01-ний өдрийн А/208 дугаар тушаалаар батлагдсан “Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам”-д заасны дагуу 2019 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрыг үйл ажиллагаа эрхэлдэг тухайн орон нутагт бүртгэж эхэлсэн. Үүний дагуу хуулийн этгээдийн салбарыг шинээр бүртгэх болон мэдээлэлд орсон өөрчлөлтийг тус нэгж дээр хүлээн авч бүртгэн, бүртгэлийн эх нотлох баримт бичгийг дугаарлан цахимжуулж хувийн хэргийг нь харьяалагдах нэгжийн архивт шилжүүлэн ажилласан байна. Үүнд: Шинээр байгуулагдсан Салбар төлөөлөгчийн газрын бүртгэл -3, Салбар төлөөлөгчийн газрын бүртгэлд орсон өөрчлөлт -10 бүртгэгдсэн.

Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлт давхардсан тоогоор 437-г бүртгэсэн байна. Үүнийг бүртгэлийн төрлөөр авч үзвэл:

Эцсийн өмчлөгч шинээр, нөхөн, өөрчлөлт бүртгэх - 410

Хэлбэр өөрчилсөн - 7,

Шилжилт хөдөлгөөн хийсэн - 4,

Гэрчилгээ дахин олгосон - 28,

Оноосон нэр өөрчлөлт - 8

Мэдээлэлд орсон бусад өөрчлөлт - 140

Татан буугдаж улсын бүртгэлээс хасалт хийгдсэн -9 байна.

Хуулийн этгээдийн бүртгэлийн системд иргэдийн хүсэлтээр 250 оноосон нэрийн давхардлыг шүүж, үүнээс 87 нэрийг сүлжээнд шинээр баталгаажуулж, оноосон нэрийг өөрчилсөн 8, хугацаа сунгасан 4 баталгаажуулалт бүртгэсэн байна.

Хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагад тамга, тэмдгийн хяналтын дугаар шинээр болон дахин нийт 91-г олгож, 41 хуулийн этгээдээс тамга тэмдгийг хураан авч архивд хүлээлгэн өгсөн.

Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчөөр бүртгүүлэх ажлын хүрээнд :

1. Ажиллах төлөвлөгөөг 2020.04.24-с 2020.12.31 хүртэлх хугацаанд боловсруулан хэлтсийн даргаар батлуулсан.

2. Хууль хэрэгжүүлэх ажил удаашралтай явагдаж байсан тул энэ ажлыг эрчимжүүлэх, эцсийн өмчлөгчийн мэдээллээ улсын бүртгэлд бүртгүүлэхэд хуулийн этгээдийг бүрэн хамруулахад чиглэгдсэн 3 гишүүнтэй ажлын хэсэг байгуулах талаар байгууллагын удирдлагад санал тавьж шийдвэрлүүлсэн. Ажлын хэсгийн 3 гишүүнд алслагдсан 12 сумдыг хуваарилан 3 баг болгон хариуцуулж ажилласан. Сумдын улсын бүртгэгч нарын дунд болзолт уралдаан зарлаж, жилийн эцэст дүгнэн урамшуулахаар төлөвлөгөөндөө тусгасан.

3. Улсын бүртгэлийн ерөнхий газрын Мэдээлэл технологийн газарт албан тоот хүргүүлэн Сүхбаатар аймагт хаягтай хуулийн этгээдийн мэдээллийн баазыг хүлээн авч, түүн дээр суурилан судалгаа гарган, 2020.01.01-ээс өмнө байгуулагдсан ба эцсийн өмчлөгчийн мэдээллээ нөхөн бүртгүүлэх шаардлагатай байгаа хуулийн этгээдийн жагсаалтыг сум сумаар нь ангилан сумдын улсын бүртгэгч нарт хуваарилан хүргүүлсэн. Хуулийн этгээдийн мэдээллийн санд байгаа нийт ХЭ-ээс Төрийн байгууллага, бусад захиргааны байгууллага, ГХО-тай компани болон 2020 оны 01-р сарын 01-ээс хойш эцсийн өмчлөгчийн мэдээллээ шинээр, нөхөн, өөрчлөлт бүртгүүлсэн хуулийн этгээдүүдийг хасч, тухайн өдрийн байдлаар нөхөн бүртгэх шаардлагатай байгаа хуулийн этгээдийн бодит жагсаалтыг гаргасан. Үүнээс 53 хувь нь аймгийн төвийн Баруун-урт сумын харъяалалтай, үлдсэн 47 хувь нь алслагдсан 12 суманд хаягтай байна. Сумдад үйл ажиллагаа явуулахаар бүртгүүлсэн хуулийн этгээдийн хувьд үйл ажиллагаа эрхлэхгүй болоод удаж байгаа, эсвэл эзэн холбогдогч нь шилжин явсан, олдохгүй газрууд нилээд гарсан.

4. Хууль хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон сумдын улсын бүртгэгч нартай цахимаар болон утсаар холбогдон сургалт хийсэн. Үүнд сумдын улсын бүртгэгч нар 100 хувь хамрагдсан.

5. Сумдын улсын бүртгэгч нарт Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн талаарх ойлголт, сургалтын гарын авлага, УБЕГ-ын даргын 2020 оны А/1270 тоот тушаалаар батлагдсан “Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг улсын бүртгэлд хөтлөх журам” , УБЕГ-ын даргын 2020 оны А/1258 тоот тушаалаар батлагдсан Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл “УБ-12” маягыг хэрхэн бөглөх чиглэлийн хамт хүргүүлсэн.

6. Аймгийн Татварын хэлтэс, сумдын татварын улсын байцаагч нар, Монгол банк, Аймгийн болон Баруун-урт сумын Тамгын газар, тусгай зөвшөөрөл олгодог холбогдох агентлаг хэлтсүүд болон хувийн хэвшлийн санхүүгийн тайлан дээр тогтмол хамтран ажилладаг нягтлан бодогч нартай хамтран ажиллах талаар албан бичиг хүргүүлэх болон биеэр уулзаж мэдээлэл солилцсноор, эцсийн өмчлөгчийн мэдээллээ нөхөн бүртгүүлэх тал дээр харилцан хамтран ажиллаж байна. Татварын байгууллагатай хамтран татвар төлөгчийн цахим тайлангийн системээр эцсийн өмчлөгчийн мэдээллийг

бүртгэх ажлыг хуулийн этгээдийн бүртгэлийн газраас зохион байгуулсан ба энэ ажлын хүрээнд тус аймгийн хуулийн этгээдийн тодорхой хэсэг нь хамрагдсан.

7. Орон нутгийн телевиз болон олон нийтийн цахим сүлжээг ашиглан эцсийн өмчлөгчийн мэдээллээ хэрхэн бүртгүүлэх талаарх мэдээлэл, шторкыг түгээх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Нэн тэргүүнд алслагдсан 12 сумдад хаягтай хуулийн этгээдрүү түлхүү чиглэгдсэн тодорхой арга хэмжээг авч ажилласнаар эдгээр сумдаас эцсийн өмчлөгчийн мэдээллээ нөхөн бүртгүүлэх шаардлагатай 427 хуулийн этгээдээс 300 орчим нь бүртгүүлснээр 70 хувийг хамруулаад байна. Төлөвлөгөөний дагуу дараагийн ээлжинд аймгийн төвийн сум болох Баруун-Урт сумын 9 багт хаягтай 518 хуулийн этгээдүүдийн эцсийн өмчлөгчийг нөхөн бүртгэх ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд Баруун-урт суман дээр өдөрлөг зохион байгуулах байсан боловч цар тахлын улмаас хойшлогдсон тул орон нутгийн ТВ-ээр зар явуулах, цахим хуудас, олон нийтийн цахим сүлжээгээр болон утсаар мэдээлэл өгч ажилласан. Ингээд нийт аймгийн 13 сумын хэмжээнд 50 орчим хувьтай хамрагдаад байна.

10. Санхүү бүртгэлийн чиглэлээр :

Улсын бүртгэлийн хэлтэс нь 2020 оны гүйцэтгэлээр Хэлтсийн дарга-1, Тасгийн дарга-2, хяналтын улсын байцаагч-1, хуулийн этгээдийн улсын бүртгэгч-1, нягтлан бодогч-1, эд хөрөнгийн тасгийн улсын бүртгэгч-2, иргэний улсын бүртгэгч-2, мэдээлэл технологийн ажилтан ба иргэний бүртгэлийн архивч-1, эд хөрөнгийн архивч-1, 13 сумын 13 улсын бүртгэгч, гэрээт жолооч, угтах үйлчилгээний ажилтан-1, үйлчлэгч-1 гэсэн нийт 28 албан хаагчидтай бүртгэлийн үйл ажиллагааг явуулж ажилласан байна.

2020 оны 12-р сарын гүйцэтгэлээр улсын төсвийн санхүүжилтээр 372,1 сая төгрөгийн санхүүжилт авч хэлтсийн өдөр тутмын үйл ажиллагаа, албан хаагчидын цалин хөлс, ХАОАТ, НДШ-ийн зардалд өглөг авлага үүсгэлгүй холбогдох хууль, дүрэм журам, тогтоолийн дагуу зарцуулсан болно.

Энэ онд тус хэлтэс нь улсын төсөвт 100 сая төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэй ажилласан ба иргэдэд түргэн шуурхай, ил тод, нийтэд хүртээмжтэй үйлчилсэний үр дүнд 120 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлж 120 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

2020 оны 04-р сард хэлтсийн даргын хүсэлт санал тавьсаны дагуу Аймгийн засаг даргын нөөц сангаас 8 сая төгрөгийн дэмжлэг авч хэлтсийн албан хаагчдын өрөө тасалгаа, иргэд үйлчлүүлдэг заал танхим, үүдний коридорын засварт зарцуулж иргэд болон албан хаагчдын тав тухтай орчинг бүрдүүлсэн.

2020 оны ээлжит УИХ болон Аймаг нийслэл, сум дүүргийн ИТХ-ын сонгуульд 111,6 сая төгрөгийн санхүүжилтийг УБЕГ-аас авч УИХ-ын сонгуулийн тухай хууль, Аймаг нийслэл, сум дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу зарцуулж санхүүгийн баримт, гүйцэтгэлийн баримт тайланг аймаг дахь Төрийн аудитын байгууллагаар хянуулж шалгуулсан.

Шалгалтаар орж ирсэн төсөв хөрөнгийг батлагдсан төсвийг холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн зөв, бодитой зарцуулсан байна гэсэн дүгнэлт авсан.

Ажил байдлын хувьд төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр жилд 12 удаа УБЕГ-ын санхүү төлөвлөлтийн газарт хүргүүлэн ажилласан болно.

Алба хаагчдаас орлогын болон үнэт цаасны мэдээг сар бүр авч сар бүрийн 8-ний дотор УБЕГ-ын холбогдох нягтлан бодогч нарт хүргүүлж байна.

Монгол улсын шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн данс хөтлөлтийг сар бүрийн 8-ний дотор хөтөлж нийт 149 мэдээлэл бүрэн оруулах байснаас 2 мэдээлэл хугацаа хоцорж оруулсан ба бусад бүх мэдээлэлийг хуулийн дагуу цаг хугацаанд нь байршуулж 99% тай дүгнэгдсэн.

Санхүүгийн улирал бүр гаргадаг тайлангуудыг цаг ямагт хуулийн хүрээнд хугацаа хоцроохгүй өгч хэвшсэн байна.

Хэлтсийн даргын 2020 оны А\11, А\17 тоот тушаалаар тооллогын комисс томилогдон байгууллагын үнэт цаас, үндсэн хөрөнгийн тооллогыг хагас бүтэн жилийн байдлаар тоолуулж, санхүүгийн программтай тулган баталгаажуулж хөрөнгийн бүрэн бүтэн байдал, үнэт цаасны ашиглалт хамгаалалтыг сайжруулан ажилласан.

“Төрийн албаны тухай хууль”, “Төсвийн тухай хууль”, “Иргэний бүртгэлийн болон эд хөрөнгийн бүртгэлийн тухай хууль” болон бусад хууль тогтоомжийг судлан иргэн болон эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийн чанар хүртээмжийг сайжруулахад анхааран ажиллаж байна.

2020 оны 04-р сараас эхлэн төсөвт байгууллагынхан албан хаагчдын цалин хөлсийг монгол улсын сангийн яамаар ЦНС-ээр олгож эхэлсэн ба ХАОАТ-ын тайлан, НДШ-ийн тайлан бусад тайлан мэдээ гаргахад хялбар болсон.

Монгол улсад Ковид-19 дэлхий нийтийг цочроосон энэ цар тахалын үед ажилтан албан хаагчдынхаа дархлааг дэмжих, халдвар хамгаалалтыг дэмжих зорилгоор 700 мянган төгрөгийн зардлыг гаргасан.

Хэлтсийн үйл ажиллагааны 2020 оны 01 дүгээр сарын 08-р сарын санхүүгийн баримтанд аймгийн төрийн аудитын газар явцын аудит орсон бөгөөд урьдчилсан байдлаар ямар нэгэн зөрчил илрээгүй.

Улсын бүртгэлийн байгууллага үүсэн байгуулагдсаны түүхт 80 жилийн ойн хүрээнд зохион байгуулах нийтийг хамарсан ажил, арга хэмжээ “COVID-19” Коронавирус цар тахлын улмаас болж хойшлогдсон болно.

**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭВИЙН ЯВУУЛАХ НӨХЦӨЛ БОЛОМЖИЙГ
БҮРДҮҮЛЭХ ЗОРИЛГООР 2021 ОНД УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗАР, ОРОН НУТГИЙН ДЭМЖЛЭГЭЭР ХИЙГДЭХ АЖИЛ :**

Аймгийн удирдлагуудад байгууллагын нөхцөл байдлыг танилцуулан дараах асуудлуудыг шийдвэрлэх боломж бүрдсэн. Үүнд :

Улсын бүртгэлийн ерөнхий газраас архивын бичиг баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор нягтруулсан шүүгээ шийдвэрлэж өгөх болсон бөгөөд холбогдох компанид захиалгаа өгсөн.

Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор албан хэрэгцээнд зориулан туулах чадвар сайтай авто машин шийдвэрлүүлэх

Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд Баруун-Урт сумын улсын бүртгэгчийг байршуулан ажиллуулах нөхцөл бололцоог ханган тогтвортой ажиллуулах /Шилэн кабель татах, төгсгөлийн төхөөрөмж FDF, шилэн кабелийн муфть, rooter, конвентер буюу шилэн кабель хөрвүүлэгч худалдан авах, сарын төлбөр гэх мэт./

Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийн үйл ажиллагааны шуурхай байдлыг ханган, иргэдэд чирэгдэлгүй үйлчлэх зорилгоор хэлтсийн үйлчилгээний зааланд "киоск" машин худалдан авч байрлуулах

Тус хэлтэст нь орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2021 онд Төр захиргааны 2 дугаар байрны 6 дугаар давхарт 10 өрөө бүхий 290 мкв талбайтай байранд шилжин орох захиалга өгсөн ба уг 16 давхар байр нь 90 хувийн гүйцэтгэлтэйгээр барилгын ажил явагдаж байна.



ТАЙЛАН НЭГТГЭСЭН : БИЧИГ

ХЭРЭГ:...../Г.БОЛОР-ЭРДЭНЭ/

ХЯНАСАН : ХЯНАЛТЫН УЛСЫН

БАЙЦААГЧ/Ц.АЛТАНЦЭЦЭГ/

ТАНИЛЦСАН : ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН

ГҮЙЦЭТГЭГЧ...../Д.БОРХҮҮ/